“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
35/10 кВ-ын"Хадат" дэд станц,
10 кВ-ын РТП-ны цахилгаан хангамжийн

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2025.02.27 №31/2025 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг	“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо
2. Техникийн нөхцөл хүссэн байршил	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 15-р хороо
3. Ажил үйлчилгээний зориулалт	Шинээр дэд станц барьж, өсөн нэмэгдэж буй цахилгаан хэрэглээг хангах,
4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	4.1 Улсын бүртгэлийн 2646161 дугаартай гэрчилгээ, 4.2 “УБЦТС” ТӨХК-ийн www.itc.energy.mn цахим системээр гаргасан хүсэлт, 4.3 “УБЦТС” ТӨХК-ийн 2025 оны 02 дүгээр сарын 05-ны өдрийн 01/210 тоот албан бичиг,
5. Олгосон чадал	5.1 35/10 кВ-ын 2*10 МВА чадалтай дэд станц, 10 кВ-ын МВА-ын РТП барих, 5.2 Хэтийн төлөвлөлт тусгагдсан цахилгаан станц, 220 кВ-ын дэд станц шинээр баригдах хүртэл тус дэд станцад шинэ хэрэглэгч холбохгүй байх.
6. Шугам сүлжээнээс хангах чадал	6.1 35/10 кВ-ын 2*10 МВА чадалтай дэд станц, 10 кВ-ын МВА-ын РТП барих,
7. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага	7.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орж, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 7.2 RS-485-ийн гаралтын интерфэйстэй олон улсын IEC61107, IEC62056 холболтын стандартуудын шаардлага хангасан байх, 7.3 Санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур суурилуулах. 7.4 Шинээр суурилуулж буй тоолуурууд нь тоолуурын нэгдсэн системд холбох. Мэдээлэл дамжуулах боломжийг бүрдүүлсэн байх. 7.5 Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангагч байгууллага “ДҮТ” ТӨХХК, “УБЦТС” ТӨХК-иудаас авах. Ажлын зураг төсөл боловсруулах шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг тухайн байгууллагаар хянуулсан байх,
8. Гүйдлийн	8.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч

трансформаторт тавигдах шаардлага	агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 8.2 Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах. 8.3 Олон улсын IEC 61869-2 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,
9. Холбогдох цэг	9.1 110/35/10 кВ-ын "Дамбадаржаа" дэд станцын 35 кВ-ын ИХБ болон 10 кВ-ын ХХБ-аас 35/10 кВ-ын "Хадат" дэд станц, 10 кВ-ын хуваарилах байгууламж (РТП-10 кВ)-ыг тэжээх,
10. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага	10.1 Шинээр барих 35/10 кВ-ын “Хадат” дэд станц: 10.1.1 Дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг олон улсын стандартын шаардлага хангасан гүйдэл, хүчдлийн трансформатор, олон улсын IEC стандартын шаардлага хангасан алсын удирлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагчаар тоноглох. 10.1.2 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн шин, дамжуулагч утас, изоляторууд болон бусад цахилгаан тоноглолуудыг зураг төслийн шатанд тооцоогоор сонгож, ашиглагч байгууллага “УБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх, 10.1.3 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн шин, оруулга, гаргалгааны үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудыг тооцоо хийж, ашиглагч байгууллага “УБЦТС” ТӨХК-тай зөвшилцөн сонгох, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх, 10.1.4 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг өргөтгөж байгаатай холбогдуулан, зураг төсөл боловсруулах шатанд дэд станцын аянгын хамгаалалт, газардуулгын байгууламжийн тооцоо, хэмжилтийг хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэх. 10.1.5 Шинээр барих дэд станцын ажлын зураг төслийг боловсруулах шатанд ашиглагч байгууллага “УБЦТС” ТӨХК-тай зөвшилцөн, батлуулах. 10.1.6 Шинээр баригдах "Дамбадаржаа" 110 кВ-ын дэд станцын 35 кВ-ын I ба II секцээс агаарын шугам татаж 35/10 кВ-ын 2*10 МВА чадалтай дэд станц барьж тэжээх, 10.1.7 Шинээр баригдах "Дамбадаржаа" 110 кВ-ын дэд станцын 35 кВ-ын I ба II секцээс агаарын шугам татаж 35/10 кВ-ын Дашчойнхор

дэд станцтай холбох,
10.1.8 Шинээр баригдах "Дамбадаржаа" 110 кВ-ын дэд станцын 10 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж 1 ком РТП хуваарилах байгууламж барьж тэжээх,
10.1.9 Шинээр баригдах 35/10 кВ-ын Хадат дэд станцын 10 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж 2 ком РП хуваарилах байгууламж барьж тэжээх,
10.1.10 Шинээр баригдах 110/35/10 кВ-ын "Дамбадаржаа" дэд станцын 10 кВ-ын I ба II секцнээс кабель шугам татаж Дэд төвийн РП хуваарилах байгууламжид холбох,
10.1.11 Шинээр баригдах 110 кВ болон 35 кВ-ын дэд станц, РП хуваарилах байгууламжуудын 10 кВ-ын I ба II секцээс кабель шугамууд татаж фидерүүдийн ачаалал хөнгөлж, хуваах,
10.1.12 Дэд өртөөнүүдийн ачаалал хөнгөлөх зорилгоор дэд өртөөнүүдийг өргөтгөх болон шинээр барих.
10.1.13 Одоо байгаа 10 кВ-ын фидерүүдийн гол шугамын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх,
10.1.14 Цахилгаан дамжуулах агаарын шугамуудад 2 талдаа хуурай салгуур бүхий Скада системд холбогдох боломжтой 10 кВ-ын реклоузерийн пунктууд суурилуулах,
10.1.15 35 кВ-ын дэд станцын 35 кВ болон 10 кВ тал нь олон улсын IEC-61850 цуврал стандартын шаардлага хангасан нумын хамгаалалт, газардлагын чиглэлтэй хамгаалалтын функц болон шинийн логик хамгаалалтын функц бүхий микропроцессорын реле хамгаалалттай ба АЧР, АПВ г.м автоматик, цахилгаан байгууламжийн дүрэм (БД43-101-03) болон ТАД-д заасан бүх төрлийн хамгаалалтыг суулган программчлах боломжтой байх. Микропроцессорын хамгаалалтыг SCADA системд холбох,
10.1.16 Шилэн кабелийн сүлжээ, шуурхай ажиллагааны холбоо, хяналт, тоолуурын нэгдсэн системд холбогдох топологи схем, тоног төхөөрөмжүүдийг маягийг ашиглагч байгуулага болох ДҮТ ТӨХХК-тай зураг төслийн шатанд зөвшилцөх.
10.1.17 Дэд станц нь холбооны сувагтай байх. Холбооны суваг нь MOXA/EDS508/SC-SS маягийн төхөөрөмжөөр тус тус мэдээлэл дамжуулах боломжтой байх.
10.1.18 Дэд станцын диспетчерийн өрөөнд 6-аас багагүй гарах дуудлага хадгалах боломжтой IP/SIP телефон аппарат төлөвлөх.
10.1.19 Холбоо мэдээллийн тоног төхөөрөмжүүдийг дэд станцыг дотоод хэрэгцээний хүчдэлгүй болсон үед тасралтгүй

тэжээлээр хангах тогмол хүчдэлийн тэжээлийн үүсгэвэртэй байна. Үүнд: Тогтмол 220В-н үүсгэвэр дээр суурилсан DC/AC инвертор эсвэл тогтмол 48В-н үүсгэвэр дээр суурилсан удирдлагын блок, шулуутгагч, инвертор, батерейн байгууламжтай байх.

10.2 35 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам:

10.2.1 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам нь MNS 6522:2015 стандартын шаардлага хангасан байх,

10.2.2 Дамжуулагчийн хөндлөн огтлолыг ачаалал, хэрэглээтэй уялдуулан сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох,

10.2.3 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр, төмөр бетон байх,

10.2.4 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, шилэн кабель бүхий аянгын тросс, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухай газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох,

10.2.5 Цахилгаан дамжуулах агаарын шугаманд сүүлийн үеийн микро процессор бүхий үндсэн болон бэлтгэл хамгаалалт, газардлагын хамгаалалтыг суурилуулах, дэд станцын удирдлагын өрөөний удирдлага хяналтын төхөөрөмжинд (HMI) холбох,

10.2.6 Шинээр суурилуулах тоолууруудыг тоолуурын нэгдсэн системд холбох.

10.2.7 Цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд “ЦДҮС” ТӨХК, “УБЦТС” ТӨХК-уудтай зөвшилцөн сонгох,

10.2.8 Цахилгаан дамжуулах агаарын шугам нь мэдээлэл дамжуулах бололцоотой 48 кортой шилэн кабель бүхий аянгын троссыг зураг төсөл боловсруулах шатанд /OPGW, G652D, Single mode,48C/, “ДҮТ” ТӨХХК, ашиглагч байгууллага “ДҮТ” ТӨХХК, “ЦДҮС” ТӨХК-уудтай зөвшилцөх,

10.3 Шинээр татах 10 кВ-ын хос кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх,

10.4 Шинээр татах 10 кВ-ын хос кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор

тодорхойлон, ашиглагч "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох,

10.5 Шинээр баригдах 10 кВ-ын хуваарилах байгууламж /РП/ нь дараах шаардлагуудыг хангасан байх. Үүнд:

10.5.1 Шинээр баригдах хуваарилах байгууламж нь 10 кВ-ын оруулгууд ба гаргалгаануудын вакуум таслуур, секц холбогч вакуум таслуур, секц холбогч салгуур, дотоод хэрэгцээний болон хүчдэлийн трансформаторууд тусдаа ячейкуудтай байх,

10.5.2 10 кВ-ын гаргалгааны ячейк нь олон улсын IEC-61850 цуврал стандартын шаардлага хангасан нумын хамгаалалт, газардлагын чиглэлтэй хамгаалалтын функц болон шинийн логик хамгаалалтын функц бүхий микропроцессорын реле хамгаалалттай ба АЧР, АПВ г.м автоматик, цахилгаан байгууламжийн дүрэм (БД43-101-03) болон ТАД-д заасан бүх төрлийн хамгаалалтыг суулган программчлах боломжтой байх. Микропроцессорын хамгаалалтыг SCADA системд холбох,

10.5.3 Халаагуурын систем, температурын датчик, кабелийн холболтын камерт нумын хамгаалалт, газардуулгын дохиолол, фазын дарааллын индикатортай, ячейкны ар талаас кабелийн үзүүр, гүйдлийн траснформаторт үзлэг шалгалт хийх цонх зэргээр тоноглогдсон байх, тэг дарааллын гүйдлийн трансформатор суурилуулж, газардлагын хамгаалалтыг оруулах,

10.5.4 Хэрэглэгчийн өсөн нэмэгдэх ачаалалд тохирсон коэффициент бүхий 0.2 нарийвчлалттай гүйдлийн трансформатор, реле хамгаалалт, хэмжүүр, тоолуурыг тооцсон ороомогтой байх, кабелийн үзүүрт тооцооны үндсэн дээр хэт хүчдэл хязгаарлагч /ОПН/ сонгох,

10.5.5 10 кВ-ын ХХБ-ын I, II секцийн ерөнхий шин нь бүрээстэй, байнгын газардуулгын хутгатай байх,

10.5.6 Хуваарилах байгууламжийн барилга нь тоосгоор баригдсан байх шаардлагатай бөгөөд цаашид өргөтгөх боломжтой байхаар барих,

10.5.7 10 кВ-ын гаргалгааны тоог хэрэглээ ачаалалтай уялдуулан, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-тай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцөх. батлуулах,

10.6 Шинээр баригдах орон сууц, барилга байгууламжуудын цахилгаан хангамжид 10 кВ-ын хуваарилах байгууламжаас хэрэглээ, ачаалалд тохирсон хөндлөн огтлол бүхий кабель шугам татаж, 10/0.4 кВ-ын дэд өртөөнүүд барьж, цахилгаан эрчим хүчээр хангах. Зураг төсөл боловсруулах шатанд холболтын схем, горим

ажиллагааг ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх, батлуулах,

10.7 Дэд станцын 10/0.4 кВ-ын трансформаторууд нь хүчдэл тохируулгын 5 шатлал бүхий олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх,

10.8 Шинээр баригдах хуваарилах байгууламжаас тэжээгдэх фидерүүдийн төгсгөлийн дэд станцууд горим үүсгэж, холбогдсон кабель шугамтай байх. Зураг төсөл боловсруулах явцад ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх,

10.9 Хуваарилах байгууламж, дэд станцын 10 кВ, 0.4 кВ-ын оруулга, гаргалгааны шугам, тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцооны дагуу суурилуулах, зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх, тавил тооцоог тус компаниар хийлгүүлэх,

10.10 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ■10%-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

10.11 Хуваарилах байгууламж, дэд станцуудад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 339 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-д заасны дагуу галын аюулгүй байдлыг хангах,

10.12 Кабелиуд нь 10 кВ-ын хүчдлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх,

10.13 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.

11. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага

11.1 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автоматикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь “Бодлогын бичиг баримт батлах тухай” Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан “Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”, “Эрчим хүчний салбарт баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг”-

	шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага "ДҮТ" ТӨХХК, "ЦДҮС" ТӨХК-уудтай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх. 11.2 Хуваарилах байгууламж, шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон үлсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага "УБЦТС" ТӨХК-уудтай зөвшилцөн сонгох. 11.3 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хангагч байгууллага "ДҮТ" ТӨХХК-уудаар хийлгэх.
12. Реактив чадлын зохицуулалт	...
13. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ	...
14. Нэг маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж	14.1 Зургийн даалгаврыг эрх бүхий байгууллагаас авах. 14.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Засгийн 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болонтай зөвшилцсөн байх. 14.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчмын схем, хоёрдогч хэлхээний зургийг ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудтай зөвшилцөх.
15. Гэнэтийн гэмтэл саатал, аваарын үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны үүсгүүр суурилуулах шаардлага	...
16. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал	16.1 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.8 “Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах” гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторх цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх. 16.2 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.13 “Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих

тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх гэж заасны дагуу хангагч байгууллага "УБЦТС" ТӨХК-д хүлээлгэн өгөх.

17. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

17.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу /2 жилийн хугацаанд/ хүчинтэй.

17.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийн дагуу зураг төслийн байгууллагаар хийлгэж, холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

17.3 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулахдаа хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг ирүүлнэ. Хэрэв баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.

18. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам

18.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, тухайн орон нутгийн газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх,

18.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,

18.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг “Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм” (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх,

18.4 “Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9 “Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй” гэж заасны дагуу өөрийн

	тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.
19. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт	19.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16, 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно. -2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-д заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ. -2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд: -2.17.1. хүчинтэй хугацаа дууссан; -2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн; -2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн; -2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн. 19.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд